



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/134

Чингис хот

“Архидалтгүй Хэнтий” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд “Архигүй орчин” арга хэмжээг зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ын “а”, 29.1.6-ын “а”, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.20, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 10 дугаар зүйлийн 10.2.7, 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.3 аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдааны 2017 оны 09 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Архидалтгүй Хэнтий” дэд хөтөлбөрийн хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Архигүй орчин” арга хэмжээг зохион байгуулахад зориулж 880000 /найман зуун наян мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.
2. Арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.
3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын “Архидалтгүй Хэнтий” дэд хөтөлбөр”-ийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс /Л.Бат-Октябрь/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231018360

Аймгийн Засаг даргын 2020 оны
 03 дугаар сарын 13 өдрийн А/134
 дугаар захирамжийн хавсралт

"Архигүй орчин" арга хэмжээний хүрээнд иргэд аж ахуйн нэгжүүдэд
 тарааж өгч байршуулах зурагт хуудас, хулдаасан хэвлэлийн тооцоо

д/д	Юунд зарцуулагдах	Нэр төрөл	Нэг бүрийн үнэ	Ширхэг	Нийт үнэ
1.	"Архигүй орчинд" нэгдэцгээе "Архидалтгүй Хэнтий" дэд хөтөлбөр гэсэн бичвэртэй хэвлэл А-4 хэмжээтэй. /Наадаг/ Аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийн самбар, гэмт хэрэг, зөрчил гардаг баг гудамж талбайд нааж байрлуулах. /Сум багуудад хүргүүлэх /	Зурагт хуудас	800	300 ширхэг	240.000
2.	Архины хэрэглээ аюулын харанга дэлдэж байна. "Архигүй орчинд" нэгдэцгээе /Зурагт хуудас Наадаг/ Аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийн самбар, гэмт хэрэг, зөрчил гардаг баг гудамж талбайд нааж байрлуулах. /Сум багуудад хүргүүлэх/	Зурагт хуудас	800	250 ширхэг	200.000
3.	Чингис хотын төв замын мэдээллийн самбарууд дээр "Архигүй орчинд" нэгдэцгээе "Архидалтгүй Хэнтий" дэд хөтөлбөр гэсэн бичвэртэй хулдаасан хэвлэл байршуулах. /1.3 метр*1 метр/	Зурагт хулдаасан хэвлэл	12000	30 ширхэг	360.000
4.	"Одоо больё" зурагт хуудас А-4 хэмжээтэй	Зурагт хуудас	800	100 ширхэг	80.000
Нийт 880.000					